

# Завхан аймаг дахь төрийн аудитын газар

**Аудитын код: ЗАА-2018/157/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189      Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70462813, 99019467, 98323586      Цахим хаяг: Khash\_aud@yahoo.com


Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888      Цахим хаяг: Munkhuu89\_org@yahoo.com

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан .....	3
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....	8
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.12	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3	Менежментийн захидал .....	12
3.1	«management_zurchil1» .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.2	«management_zurchil2» .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	17
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	17
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	17
4.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..	<b>Error! Bookmark not defined.</b>
4.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17

## 1 Аудитын гэрчилгээ

 <b>ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 81000 Улиастай, Завхан аймаг Утас/Факс: 7046-36-12	<b>ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Ө.БОЛД ТАНАА</b>
<u>2018.03.02</u> № <u>184</u>	
танай _____ -ны № _____ -т	
<b>Аудитын гэрчилгээ</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
<b>Сөрөг санал дүгнэлт</b>	
<p>Аймгийн Онцгой байдлын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн "Сөрөг санал дүгнэлт" гаргаж байна.</p>	
<b>Санал дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Аймгийн Онцгой байдлын газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
<b>Аудитын гол асуудал</b>	
<p>Санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдүүлэлт байхгүй, шатахууны зарцуулалт, жолоочийн тооцоо бодсон акт, тайлангүйгээр зарлага болгосон, мөн</p>	
<b>152 517</b>	

зориулалтын бус зарцуулсан зэрэг зөрчлүүд нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн, 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалт, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, бодитой байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.УЛАМБАЯР

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Завхан аймгийн Онцгой байдлын газрын дарга /Хурандаа/ *Өвдөл овогтой Болд*-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор *Завхан аймгийн Онцгой байдлын хэлтэс*-ын 2017-12-31 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын* -ын 2017-12-31 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018-02-20 - наас 2018-02-29 – ны хооронд хийж, аудитын тайланг 2018-03-03 - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр

төлөвлөн, *Завхан аймгийн Онцгой байдлын газрыг* Аудитор Б.Мөнхнасан хариуцаж хэрэгжүүлэв.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2017-12-31 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018-02-18 - нд төрийн аудитын байгууллагад 2018-02-27-ны өдрийн 27/55–р албан бичгээр ирүүлсэн байна.*

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын “Болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, гамшгийн аюулаас хүний амь нас, эд хөрөнгө, мал амьтан, хүрээлэн байгаа орчныг авран хамгаалах, сэргээн босгох дээрх үйл ажиллагаанд ард иргэдийг сурган дадлагажуулах.” эрхэм зорилгын дор Онцгой байдлын ерөнхий газар-ийн эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:*

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:*

Тайлант хугацаанд *Завхан аймгийн Онцгой байдлын газар*

*“1. Орон нутгийн гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлэх, ард иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах*  
*2. Албан хаагчдын мэргэжилийн ур чадвар, цэргийн хэргийн мэдлэг, ажлын хариуцлага чанар үр дүнг дээшлүүлэх*  
*3. Албан хаагчдын ажлын байр ажиллах орчин, ар гэр нийгмийн асуудлыг сайжруулах”*  
дэвшүүлэн ажиллажээ.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын* талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын* удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- 

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тус байгууллага нь ажилчдын ажиллах ая тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх үүднээс байгууллагын барилга ажилчдын орон сууцны асуудлыг шийдвэрлэж байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

*(Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой бүрэн нийцэхгүй байна*

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын* төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах 2 гэж үзлээ.

*Завхан аймгийн Онцгой байдлын газар* санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “ACOLOUS” програм хангамж ашиглажээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын* бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай

холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 10 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-В-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 7 асуудал эрсдэл өндөр, 4 асуудал эрсдэл дунд, 3 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-В-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 21 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 7 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлого -ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт орлого -ийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь 1 хувиар тогтоосон-тай холбоотой юм.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын 2017-12-31 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1663,2 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 16,6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.*

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 10 эрсдэлтэй асуудалд 10 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 100 хувь буюу 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.



Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	1	47,7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0	
3	Албан шаардлага өгсөн	0	0	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0	
	Дүн	1		

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Онцгой байдлын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд 1350500 төгрөгийн хөрөнгө дутуу бүртгэсэнийг залруулсан,

Тээвэр шатахуун, багаж техник хэрэгсэл, урсгал засварын зардлаас нийт 65133691 төгрөгийн зөрчил илэрсэнээс 47608869 төгрөгийг зориулалт бус зарцуулсан, баримтын бүрдүүлэлт дутуу 17524822 төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоныг удирдлагын зөвлөлөөр хэлэлцэн дутуу баримт материалуудыг бүрдүүлэхээр шийдвэрлэсэн.

Тус шийдвэрийн дагуу:

№	Нэр	Нийт зөрчил	Зөрчил	Төлбөрийн акт
1	Нийт илэрсэн зөрчил	65133691	47608869	17524822
2	1-р Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу бүрдсэн баримтын дүн	17425710	6278218	11147492
3		47707981	41330651	6377330

4	2-р Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу бүрдсэн баримтын дүн			6377330
5	3-р Удирдлагын зөвлөлийн хурлаар төлбөрийн актыг чөлөөлж зөрчилд авсан.		6377330	
<b>Нийт дүн</b>		<b>47707981</b>	<b>47707981</b>	<b>0</b>

Шатахууны зардлаас холбогдох дээд байгууллагын шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө, бараа материал бэлтгэсэн байна.

### 2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

*Төлбөрийн актыг удирдлагын зөвлөлөөр 4-н удаа хэлэлцэж хүчингүй болгохоор шийдвэрлэсэн.*

#### **Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал**

*Онцгой байдлын газрын Ерөнхий нягтлан бодогч Ц.Сүхбатад сахилгын шийтгэл ногдуулахаар албан шаардлага хүргүүлсэн.*

### 2.9.2 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

*Онцгой байдлын газрын Ерөнхий нягтлан бодогч Ц.Сүхбатад сахилгын шийтгэл ногдуулахаар албан шаардлага хүргүүлэхээр шилжүүлсэн.*

### 2.9.3 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

*Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал гараагүй болно.*

## 2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхан шатны баримтын бүрдүүлэлт, зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх

Нэмэлт санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулах, зардал хэтрүүлэх зэрэг зөрчлүүд байна.

### 2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Завхан аймгийн Онцгой байдлын хэлтэс өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1601927700, хөрөнгийн зардалд 0 төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1601927700	1545737527.3	-825%	-Е7
1.1	Урсгал зардал	1601927700	1545737527.3	-825%	-Е7
1.2	Хөрөнгийн зардал	0	0	0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	0	0	0.0%	0.0
2	Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр				
2.1	Улсын төсвөөс санхүүжих				
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос				

Төсөвт зардлын гүйцэтгэл (110) хувь байгаа нь Түлш халаалтын зардал хэтэрсэн байгаа нь тэс суман дахь барилгын халаалтын зардал батлагдаагүй байснаас шалтгаалан хэтэрсэн, Шуудан холбоо интернетийн зардал хэтэрсэн нь интернетийн хурд хүрэлцдэггүй тул хурд нэмүүлсэнтэй холбоотойгоор зардал хэтэрсэн байна. холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт (0) хувь байгаа нь Байхгүй холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 114245341, хөрөнгийн зардалд төгрөг байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## 2.12 Шилэн дансны мэдээлэл

Завхан аймгийн Онцгой байдлын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 10 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 10 горим сорил хэрэгжүүлэв.

*Алдаа зөрчил илрээгүй байна.*

## **2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017-12-31 оны жилийн эцсийн байдлаар Бүрэн хэрэгжсэн дүнтэй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг *Завхан аймгийн Онцгой байдлын газар* 2018-03-14-ны өдрийн 27/79 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

*Өмнөх зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлээгүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй бусад холбогдох стандарт зөрчсөн байна.*

## **2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид *Завхан аймгийн Онцгой байдлын газрын* 2017-12-31 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

*Завхан аймгийн Онцгой байдлын газрын* 2017-12-31 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ үнэн зөв тайлагнасан боловч холбогдох хууль, УСНББОУС, Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаатай, үнэн зөв, шударга илэрхийлээгүй байна гэж үзэж “Сөрөг” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **АУДИТЫНТАЙЛАНГ**

#### **ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР	Л.УЛАМБАЯР	2018.03.05
АУДИТЫНМЕНЕЖЕР	Г.ХАШЦЭЦЭГ	2018.03.05

#### **БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР	Б.МӨНХНАСАН	2018.03.05
---------	-------------	------------

## Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Завхан аймгийн Онцгой байдлын газрын* нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.**

### 2.15 Онцгой байдлын газрын 2017 оны санхүүгийн тайлангаас илэрсэн алдаа зөрчил

#### Илрүүлэлт

1. Тээвэр шатахууны зардалаас 47,707,981 төгрөгийг анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу зориулалтын бус зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн, 13.1. “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7. “Анхан шатны баримтын

#### Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн, 13.1. Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтууд, Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн

бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтууд, Сангийн сайдын 2013 оны 73-р тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам-ыг зөрчсөн байна.

төсөвт зохицуулалт хийх журам-ыг мөрдөж ажиллах.

### **Хариуцах ажилтан**

Онцгой байдлын газрын дарга  
/Хурандаа/ Ө.Болд,

Онцгой байдлын газрын ерөнхий нягтлан  
бодогч /дэслэгч/ Ц.Сүхбат

### **Эрсдэл**

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх  
Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах

### **Төсвийн захирагчийн хариу**

АУДИТААР АЖИГЛАГДСАН ЭНЭХҮҮ АЛДАА  
ЗӨРЧИЛ ДУТАГДЛЫГ ТӨСВИЙН ЗАХИРАГЧ  
ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БОЛНО.

**Менежментийн захидлаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж хариуг  
2018 оны 06 дугаар сарын 01-ны дотор ирүүлэхийг мэдэгдэе.**

## **АУДИТЫНТАЙЛАНГ**

### **ХЯНАСАН:**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

2018.03.05

АУДИТЫНМЕНЕЖЕР

Г.ХАШЦЭЦЭГ

2018.03.05

### **БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Б.МӨНХНАСАН

2018.03.05

Завхан аймаг дахь төрийн аудитын газар



## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

### Аудитын код: ЗАА-2018/157/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189 Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70462813, 99019467, 98323586 Цахим хаяг: Khash\_aud@yaoo.com

Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888 Цахим хаяг: Munkhuu89\_org@yahoo.com



2.16

**Илрүүлэлт**

**Зөвлөмж**

**Хариуцах ажилтан**

**Эрсдэл**

**Төсвийн захирагчийн хариу**

### **3 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

---

**3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

**3.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

**3.3 Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**3.4 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**